



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВ

Баянхонгор аймаг

ЗӨСТ нь байгалийн голомтот болон зоонозын халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлийг тандан судлах, хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, лабораторийн тусламж үйлчилгээ үзүүлэх, зоонозын хүний өвчлөлийн, тохиолдол дэгдэлтийн үеийн эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилладаг.

Түүхэн замнал

Бүтэц, зохион
байгуулалт

Хамт олон

Алсын хараа
Эрхэм зорилго

Үйл ажиллагаа

ХАЯГ:

Зоонозын Өвчин
Судлалын Төв,
Баянхонгор аймаг,
Номгон сум, 1-р баг

Утас: 70442778,
70444078

www.facebook.com/Баянхонгор-аймгийн-Зоонозын-Өвчин-Судлалын-Төв

Цахим шуудан:
g_bilgee0721@yahoo.com

Түүхэн замнал



Байгууллагын анхны байр



Байгууллагын одоогийн байр

Анх 1944 онд Баянхонгор аймгийн Заг суманд БНМАУ-ын Бага хурлын 1943 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 25-р тогтоолоор “Тарваган тахал эсэргүүцэх пункт” нэртэйгээр одоогийн байгууллагын суурь тавигдсан юм. Түүнээс хойш дараах нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- 1968 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор “Гоц аюулт өвчнийг эсэргүүцэн судлах аймаг дундын станц”,
- 1991 онд “Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газар”,
- 2007 оноос “Байгалийн голомтот халдварт өвчин судлалын төв”,
- 2012 оноос “Зоонозын өвчин судлалын төв”

Тус төв нь 1944-1960 онд Заг суманд, 1961-1972 онд Жаргалант суманд байршиж байгаад 1973 оноос аймгийн төвд шилжин, одоогоор 29 орон тоотойгоор ажиллаж байна.

Бүтэц, зохион байгуулалт



Хамт олон



Алсын хараа

Бүхнээс түрүүлж бүгдэд туслая

Эрхэм зорилго

Байгууллагын стратеги, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг шинэчлэн, эрсдэлгүй орчныг бүрдүүлэн сургалтын чанар, цар хүрээг өргөжүүлэн дэвшилтэт технологи нэвтрүүлэн ажиллана.

Үйл ажиллагааны чиглэл

- Байгалийн голомтот, зоонозын өвчний байгалийн голомтыг шинжлэн судалж, голомтыг тандах, тогтоох, хянах
- Байгалийн голомтот, зоонозын өвчний дуудлагын бэлэн байдлыг хангаж шуурхай, оновчтой арга хэмжээг хэрэгжүүлэх
- Хүний өвчлөлийн оношийг лабораториор 100% баталгаажуулах
- Голомтот нутгийн болон эрсдэлтэй бүлгийн хүн амыг тарваган тахал, боом, хачигт энцефалитын дархлаажуулалтанд хамруулах, тархвар судлалын заалтаар галзуу өвчний дархлаажуулалт хийх
- Зоонозын өвчний талаар хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох

Үйл ажиллагааны зурагт агшин









